

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2026.04.06

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ болон Иран хэлэлцээр хийж чадахгүй бол Ираны голлох эрчим хүчний үйлдвэрүүдийг бүрэн устгааа мэдэгдлээ.
- Урт хугацаанд энэ дайн сунжрах нь АНУ-д ашиггүй.
- АНУ-ын 3-р сарын ажилгүйдлийн түвшин 4.3%-д хүрч буурлаа.
- Трамп Ирантай хэлэлцээр хийх хугацаагаа лхагва гарагийн 08:00 цаг хүртэл хойшлууллаа.
- 2026 оны эхний хагас жилд АНУ-ын зах зээл чиглэлгүй байж болох ч сүүлийн хагаст өсөлтөө үргэлжлүүлнэ.
- БНХАУ технологийн компаниудаа дэмжинэ.
- Дайны нөхцөл байдлаас үл хамааран БНХАУ их хэмжээний газрын тосны нөөцтэй.



S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.03.30-04.05

АНУ-ЫН ИНДЕКСҮҮД САВЛАГААТАЙ Ч ӨСӨЛТТЭЙ БАЙЛАА

АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт савлагаатай байсан ч эерэг өсөлтөөр хаагдлаа. Долоо хоногийн эхэнд зах зээл унасан ч мягмар, лхагва гарагт Ерөнхийлөгч Donald Trump Иран дахь цэргийн ажиллагааг багасгаж магадгүй гэсэн дохио өгснөөр хүчтэй өсөлт ажиглагдсан. Гэвч лхагва гарагийн оройн мэдэгдэлд тодорхой тайван шийдэл, хугацаа зарлаагүй нь зах зээлийн итгэлийг сулруулж, нефтийн үнэ өсч, хувьцаанд дарамт үзүүлсэн. Гэсэн ч долоо хоногийн төгсгөлд зах зээл сэргэж, нийт дүнгээр эерэг гүйцэтгэлтэй хаагдсан байна.

Ираны дайн 36 дахь өдрөө үргэлжилж, зах зээл 2025 оны "Liberation Day"-аас хойших хамгийн их савлагаатай үеийг туулж байна. Ерөнхийлөгч Donald Trump-ын өмнөх зөрчлүүд ихэвчлэн хэлэлцээрээр дуусдаг байсан ч энэ удаад хоёр талын идэвхтэй сөргөлдөөнөөс шалтгаалан хугацаа сунжирч байна. Гэсэн ч нефть, инфляц, эдийн засгийн дарамт нэмэгдэж буй нөхцөлд дайн урт хугацаанд үргэлжлэх нь АНУ-д ашиггүй тул ойрын хугацаанд шийдэлд хүрэх магадлал өндөр хэвээр байна. Өнөөгийн нөхцөл байдал нь хэн түрүүлж буулт хийхийг шийдэх тэвчээрийн тоглолт болж байна.

АНУ-ЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН БУУРЛАА

АНУ-ын харуулсан хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн үзүүлэлтүүд эерэг болон сул дохиог зэрэг холимог дүр зураг үзүүлж байна. шинээр ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо 202,000 болж буурсан нь хөдөлмөрийн зах зээл богино хугацаанд харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна. Үүнээс гадна ажлын байрны эрэлт буурч, нээлттэй ажлын байр 6.9 сая болж багассан, ажилд авах түвшин 2020 оноос хойших хамгийн доод түвшинд хүрсэн байна. Мөн АНУ-ын 3-р сарын ажилгүйдлийн түвшин 4.3% хүртэл буурсан байна.

S&P 500 индекс



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.03.30–04.05

ГАЗРЫН ТОСНЫ ХАНШ ЦААШДЫН ТӨЛӨВТ ДАРАМТ БОЛЖ БАЙНА

Дотоодын хэрэглээ сул хэвээр байгаа нөхцөлд Хятадын компаниуд гадаад эрэлтэд түшиглэн өсөлтөө хадгалах стратеги баримталж байна.


Гэвч энэ эерэг хандлагад гадаад орчны шинэ эрсдэл үүсч эхэллээ. АНУ–Ираны зөрчлөөс үүдэн дэлхийн нефтийн нийлүүлэлт тасалдаж, Ормузын хоолой хаагдсанаар эрчим хүчний үнэ өсөх дарамт бий болсон нь үйлдвэрлэлийн зардалд нөлөөлөх гол хүчин зүйл болж байна. Нефтийн үнэ өсөх нь тээвэр, үйлдвэрлэл, эрчим хүчний зардлыг нэмэгдүүлж, улмаар компаниудын ашигт ажиллагааг бууруулах эрсдэлтэй.

Үүний эсрэг Хятадын засгийн газар шатахууны үнийг нэмсэн ч өсөлтийг хязгаарлаж, хэрэглэгчдэд ирэх дарамтыг багасгах бодлого барьж байна. Мөн Хятад улс том хэмжээний нефтийн нөөцтэй, олон төрлийн эрчим хүчний эх үүсвэр ашигладаг, түүнчлэн Иранаас нефть нийлүүлэлт үргэлжилж байгаа зэрэг нь бусад оронтой харьцуулахад эрсдэлийг харьцангуй бууруулж байгаа хүчин зүйл болж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭКСПОРТЫН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТИЙГ ЦУЦАЛЛАА

Хятад улс 4-р сарын 1-нээс эхлэн нарны хавтан, батарей болон зарим үйлдвэрийн материал зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнд олгодог экспортын НӨАТ-ын буцаан олголтыг зогсоож эхэллээ. Энэхүү шийдвэр нь дотоодын илүүдэл үйлдвэрлэлийг бууруулах, мөн олон улсын худалдааны маргааныг намжаах зорилготой юм. Гэвч энэ өөрчлөлт нь экспортлогч компаниудын зардлыг нэмэгдүүлж, ашигт ажиллагаанд дарамт үзүүлэх магадлалтай.

Hang Seng индекс



2026 оны 1 дүгээр сарын 26 өдрөөс эхэлсэн уналтын хэмжээс дууссан байх боломжтой сигналууд ажиглагдаж байна. Мөн тус богино хугацааны уналтын түвшин 2025 оны 4 сард эхэлсэн өсөлтийн трендийн дундаж утга болох 61.8 хувийн түвшинд дэмжлэг авснаас харахад ханшийн өсөлт дараачийн хүчтэй эсэргүүцлийн түвшин болох 25,879-26,082 түвшинд хүрэх боломжтой байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

http://eps.sh/cal

© 2026 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

http://eps.sh/cal

© 2026 Earnings Whispers